

## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, ар талын албаны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** СНАГ-2026/297/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2026 он	Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: <a href="mailto:naranchimegts@audit.gov.mn">naranchimegts@audit.gov.mn</a> Аудитын менежер Б.Долгорсүрэн Утас: 261885 Цахим хаяг: <a href="mailto:dolqorsurenb@audit.gov.mn">dolqorsurenb@audit.gov.mn</a> Ахлах аудитор С.Отгонхорлоо Утас: 261740 Цахим хаяг: <a href="mailto:otgonkhorloos@audit.gov.mn">otgonkhorloos@audit.gov.mn</a> Аудитор С.Шийлэгмаа Утас: 261740 Цахим хаяг: <a href="mailto:shiilegmaas@audit.gov.mn">shiilegmaas@audit.gov.mn</a>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	13
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	14
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	14
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	14
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	16
3.5.1 Төсвийн төлөвлөлт .....	16
3.5.2 Төсвийн гүйцэтгэл .....	16
3.5.3 Нэмэлт төсөв.....	18
3.6 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл.....	18
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	19
4.1 Ерөнхий зүйл.....	19
4.2 Материаллаг байдал .....	19
4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	19
4.3.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	19
4.3.2 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	19
4.4 Завсрын аудитын үр дүн.....	20
4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн .....	20
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	20
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	21
5.1 Төлбөрийн акт .....	21
5.2 Албан шаардлага .....	21
5.3 Зөвлөмж .....	22
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	23

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
СНАГ	Санхүү, нийцлийн аудитын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,  
Цахим шуудан: info@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 06/355

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, ар талын албаны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт (АОУС), түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Монгол Улсад цэргийн дээд “Генерал” цол олгож эхэлсний 81 жилийн ой, “Монгол генералын өдөр”-ийг тохиолдуулан цагдаагийн байгууллагын генералуудад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээ, “Бүс нутгийн аюулгүй байдал, үндэстэн дамнасан зохион байгуулалттай тэмцэх” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулахад нийт 85,300.0 мянган төгрөгийн зардал гаргасан байна.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.2.3.3-т “Төрийн үйлчилгээнд процессын дахин инженерчлэл хийх ажлыг үргэлжлүүлэн төрд байгаа мэдээллийг иргэн, аж ахуйн нэгжээс шаарддаг байдлыг бүрэн халах, иргэн, хуулийн этгээд нэг удаа бүртгүүлээд төрийн цахим үйлчилгээг шуурхай, чирэгдэлгүй авах нөхцөлийг бүрдүүлнэ” гэж заасныг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2025 оны А/71, А/175 дугаар хамтарсан тушаалыг үндэслэн 8 удаагийн сургалтыг зохион байгуулахад 17,700.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

## Аудитын гол асуудал

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх боломжгүй, энхийг сахиулах ажиллагаанд ашиглах 344 нэр төрлийн 92082 ширхэг 784,968.2 мянган төгрөгийн бараа, материалыг Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2025 оны баталсан төсвөөс худалдан авахаар шийдвэрлэж, нэр бүхий хуулийн этгээдтэй 7 гэрээг байгуулж, тайлант онд 82 нэр төрлийн 2710 ширхэг 468,000.5 мянган төгрөгийн бараа материал худалдан авах 4 гэрээний хэрэгжилтийг дүгнэсэн байна.

## Бусад асуудал

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтөөр өмнөх оны үр дүнг “Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3-т “Цэргийн алба хаагчийн нэг удаагийн тэтгэмжийн 18 сар хүртэлх хугацаанд ногдох хэсгийг цэргийн алба хаасны тэтгэвэр авах эрх үүссэнээс хойш үргэлжлүүлэн алба хааж байгаа офицер, ахлагчид өөрийнх нь хүссэнээр цэргийн албанаас чөлөөлөгдөхөөс өмнө урьдчилан олгож болно” гэж заасны дагуу 13 албан хаагчид олгосон нэг удаагийн тэтгэмжийн 739,302.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

## Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>38,693,291,029.90</b>	<b>53,127,842,143.11</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>1,881,003,952.94</b>	<b>2,407,668,586.95</b>
<b>311</b>	<b>Кассанд байгаа бэлэн мөнгө</b>	<b>350,000.00</b>	<b>350,000.00</b>
31110	Төгрөг	350,000.00	350,000.00
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>1,880,653,952.94</b>	<b>2,407,318,586.95</b>
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	<b>1,880,653,952.94</b>	<b>2,407,318,586.95</b>
31211	Төрийн сангийн харилцах	1,880,653,952.94	2,407,318,586.95
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>52,713,985.00</b>	<b>165,994,340.99</b>
33300	Татаас, санхүүжилтийн авлага		128,819,891.99
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	<b>52,713,985.00</b>	<b>37,174,449.00</b>
3351	Байгууллагаас авах авлага	22,519,818.00	9,860,000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	30,194,167.00	27,314,449.00
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	<b>17,162,602,660.45</b>	<b>8,056,535,506.53</b>
34600	Урьдчилж гарсан зардал	4,772,978,085.40	2,611,772,057.40
<b>3471</b>	<b>Урьдчилгаа тооцоо</b>	<b>12,389,624,575.05</b>	<b>5,444,763,449.13</b>
34711	Бараа материал бэлтгэх урьдчилгаа	3,081,423,026.75	1,125,828,309.75
34712	Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	9,308,201,548.30	4,318,935,139.38
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>4,417,886,753.79</b>	<b>17,136,603,338.92</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>1,508,818,233.13</b>	<b>7,030,292,611.87</b>
35110	Тусгай зориулалттай материал	1,507,756,563.13	7,030,142,611.87
35130	Эм боох материал	1,061,670.00	150,000.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	66,428,393.00	86,265,563.10
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>2,826,764,443.66</b>	<b>9,999,044,262.95</b>
35410	Бичиг хэргийн материал	114,087,257.00	653,145,689.50
35420	Аж ахуйн материал	38,220,309.00	14,330,289.00
35440	Түлш, шатах тослох материал	1,018,701,549.05	1,006,416,549.05
35450	Барилгын засварын материал		4,142,130.00
35470	Бусад хангамжийн материал	1,655,755,328.60	8,321,009,605.40
35600	Мал амьтад	15,875,684.00	21,000,901.00
<b>36</b>	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>	<b>15,179,083,677.72</b>	<b>25,361,040,369.72</b>
36800	Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/	15,179,083,677.72	25,361,040,369.72
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,931,033,964.89</b>	<b>2,650,571,610.81</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>2,931,033,964.89</b>	<b>2,650,571,610.81</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>2,694,492,874.89</b>	<b>2,414,030,520.81</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,345,373,774.28	2,345,373,774.28
39202	Хуримтлагдсан элэгдэл	-368,297,015.22	-451,963,499.94
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	33,339,200.00	33,339,200.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-1,766,666.88	-11,169,648.48
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	480,960.66	480,960.66
39208	Хуримтлагдсан элэгдэл	-240,480.30	-336,672.42
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	605,651,851.74	427,243,951.74
39214	Бусад үндсэн хөрөнгө	108,151,059.60	108,151,059.60
39215	Хуримтлагдсан элэгдэл	-28,199,808.99	-37,088,604.63
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>236,541,090.00</b>	<b>236,541,090.00</b>
39303	Бусад биет бус хөрөнгө	236,541,090.00	236,541,090.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>41,624,324,994.79</b>	<b>55,778,413,753.92</b>

Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, ар талын албаны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитын тайлан

<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>1,426,102,829.95</u></b>	<b><u>1,989,574,952.95</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>1,426,102,829.95</u></b>	<b><u>1,989,574,952.95</u></b>
<b>413</b>	<b>Өглөг</b>	<b><u>48,619,818.00</u></b>	<b><u>23,138,059.00</u></b>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	338,850.00	
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	<b><u>48,280,968.00</u></b>	<b><u>23,138,059.00</u></b>
41361	Байгууллагад төлөх өглөг	48,040,968.00	22,898,059.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	240,000.00	240,000.00
<b>414</b>	<b>Урьдчилж орсон орлого</b>	<b><u>1,377,483,011.95</u></b>	<b><u>1,966,436,893.95</u></b>
41430	Барьцаа, дэнчингийн урьдчилж орсон орлого	1,361,937,145.95	1,943,902,859.95
41440	Бусад урьдчилж орсон орлого	15,545,866.00	22,534,034.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>40,198,222,164.84</u></b>	<b><u>53,788,838,800.97</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b><u>40,198,222,164.84</u></b>	<b><u>53,788,838,800.97</u></b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	330,084,811.40	330,084,811.40
51101	Өмч: - төрийн	330,084,811.40	330,084,811.40
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b><u>39,835,107,054.88</u></b>	<b><u>53,425,723,691.01</u></b>
51210	Өмнөх үеийн үр дүн	39,835,107,054.88	40,574,409,439.88
51220	Тайлант үеийн үр дүн		12,851,314,251.13
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	33,030,298.56	33,030,298.56
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>41,624,324,994.79</u></b>	<b><u>55,778,413,753.92</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>81,230,034,298.83</b>	<b>111,516,559,815.02</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>6,774,497,470.83</b>	<b>9,364,616,966.70</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>6,180,730,257.83</b>	<b>9,364,616,966.70</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,648,779,726.49	7,936,526,541.70
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		209,753,329.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,783,104.25	
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	3,643,996,622.24	7,726,773,212.70
120009	Бусад орлого	2,531,950,531.34	1,428,090,425.00
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	<b>593,767,213.00</b>	<b>0.00</b>
122002	Хандив тусламж /гадаад/	593,767,213.00	
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>74,455,536,828.00</b>	<b>102,151,942,848.32</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>71,747,724,362.00</b>	<b>93,245,611,113.32</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	59,745,066,200.00	58,958,668,467.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	12,002,658,162.00	34,286,942,646.32
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>2,707,812,466.00</b>	<b>8,906,331,735.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	56,029,465.00	
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,537,180,800.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	103,071,305.00	6,299,898,235.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	11,530,896.00	2,606,433,500.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>14,529,329,376.83</b>	<b>21,779,725,772.67</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>14,529,329,376.83</b>	<b>21,779,725,772.67</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>9,391,295,838.72</b>	<b>16,299,109,283.71</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>2,807,780,638.40</b>	<b>3,390,193,790.55</b>
210101	Үндсэн цалин	1,560,968,664.98	1,873,674,311.25
210102	Нэмэгдэл	1,134,457,281.44	1,241,392,373.60
210103	Унаа хоолны хөнгөлөлт	937,000.00	91,485,000.00
210104	Урамшуулал	111,417,691.98	183,642,105.70
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>58,993,551.72</b>	<b>75,331,685.55</b>
210201	Тэтгэврийн даатгал	2,166,858.00	7,359,857.12
210202	Тэтгэмжийн даатгал	254,925.00	865,865.55
210203	ҮОМШӨ-ний даатгал	203,940.00	432,932.77
210204	Ажилгүйдлийн даатгал	50,985.00	432,932.77
210205	Эрүүл мэндийн даатгал	56,316,843.72	66,240,097.34
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>37,510,462.91</b>	<b>43,914,644.64</b>
210301	Гэрэл, цахилгаан	19,616,544.00	27,052,451.84
210302	Түлш, халаалт	14,232,248.42	12,693,126.59
210303	Цэвэр, бохир ус	3,661,670.49	4,169,066.21
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>768,302,947.99</b>	<b>454,092,562.50</b>

Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, ар талын албаны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитын тайлан

210401	Бичиг хэрэг	20,213,850.00	59,816,722.50
210402	Тээвэр, шатахуун	57,035,000.00	65,785,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	124,990,443.97	123,413,910.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		1,440,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	73,441,932.58	179,229,254.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		11,770,210.00
210408	Бараа материал акталсны зардал	492,621,721.44	12,637,466.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>1,346,653,786.22</b>	<b>1,069,631,034.41</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	553,000.00	101,522.00
210502	Хоол, хүнс	379,903,429.31	494,570,659.51
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	966,197,356.91	574,958,852.90
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>594,627,427.00</b>	<b>503,086,322.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл		19,112,000.00
210604	Урсгал засвар	594,627,427.00	483,974,322.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>329,389,129.45</b>	<b>128,269,487.20</b>
210701	Гадаад албан томилолт	313,976,023.00	97,328,637.20
210702	Дотоод албан томилолт	15,178,600.00	30,940,850.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	234,506.45	
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>3,170,332,717.91</b>	<b>9,767,880,493.33</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,112,413,908.91	7,354,971,209.00
210803	Даатгалын үйлчилгээ	261,701,801.00	227,277,276.63
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	66,133,200.00	1,016,091,218.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,730,083,808.00	1,169,540,789.70
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>277,705,177.12</b>	<b>866,709,263.53</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		133,097,471.45
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	182,667,166.00	628,376,238.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	95,038,011.12	105,235,554.08
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>5,138,033,538.11</b>	<b>5,480,616,488.96</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>123,280,799.00</b>	<b>147,408,000.00</b>
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	123,280,799.00	147,408,000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>2,393,603,419.87</b>	<b>2,395,156,156.77</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	50,753,404.00	16,835,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	936,454,481.43	820,079,689.77
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,406,395,534.44	1,558,240,967.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>2,621,149,319.24</b>	<b>2,938,052,332.19</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,621,149,319.24	2,938,052,332.19
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>66,700,704,922.00</b>	<b>89,736,834,042.35</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>61,598,036,472.95</b>	<b>76,885,519,791.22</b>
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	61,598,036,472.95	76,885,519,791.22
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>-61,598,036,472.95</b>	<b>-76,885,519,791.22</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>5,102,668,449.05</u></b>	<b><u>12,851,314,251.13</u></b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>67,532,587,520.54</b>	<b>105,311,288,170.32</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>5,079,468,854.54</b>	<b>3,159,345,322.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>5,079,468,854.54</b>	<b>3,159,345,322.00</b>
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>2,547,518,323.20</b>	<b>1,731,254,897.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,431,300,040.95	1,731,254,897.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	116,218,282.25	
120009	Бусад орлого	2,531,950,531.34	1,428,090,425.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>62,453,118,666.00</b>	<b>102,151,942,848.32</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>59,745,066,200.00</b>	<b>93,245,611,113.32</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	59,745,066,200.00	58,958,668,467.00
131005	Хөрөнгийн санхүүжилт		34,286,942,646.32
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>2,708,052,466.00</b>	<b>8,906,331,735.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	56,029,465.00	
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,537,180,800.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	103,071,305.00	6,299,898,235.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	11,770,896.00	2,606,433,500.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>65,351,057,125.09</b>	<b>69,762,352,460.99</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>65,351,057,125.09</b>	<b>69,762,352,460.99</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>60,396,199,462.98</b>	<b>64,533,525,311.04</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>2,809,325,798.89</b>	<b>3,390,731,574.92</b>
210101	Үндсэн цалин	1,457,978,076.87	1,869,738,164.42
210102	Нэмэгдэл	1,239,242,957.02	1,240,804,295.39
210103	Унаа хоолны хөнгөлөлт	937,000.00	91,621,500.00
210104	Урамшуулал	111,167,765.00	188,567,615.11
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>59,980,699.23</b>	<b>74,793,901.18</b>
210201	Тэтгэврийн даатгал		6,031,266.11
210202	Тэтгэмжийн даатгал		713,287.89
210203	ҮОМШӨ-ний даатгал		356,643.94
210204	Ажилгүйдлийн даатгал		356,643.94
210205	Эрүүл мэндийн даатгал	59,980,699.23	67,336,059.30
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>107,683,969.91</b>	<b>118,614,644.64</b>
210301	Гэрэл, цахилгаан	19,615,544.00	27,052,451.84
210302	Түлш, халаалт	84,406,755.42	87,393,126.59
210303	Цэвэр, бохир ус	3,661,670.49	4,169,066.21
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>1,473,799,570.42</b>	<b>403,761,642.00</b>
210401	Бичиг хэрэг	83,949,420.00	89,334,256.00
210402	Тээвэр, шатахуун	483,110,151.00	56,780,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	901,586,899.42	123,393,910.00
210404	Ном, хэвлэл		26,030,000.00

Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, ар талын албаны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитын тайлан

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		1,440,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,153,100.00	106,783,476.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>27,937,940,745.33</b>	<b>37,326,250,319.19</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		1,775,772.00
210502	Хоол, хүнс	2,435,657,569.10	530,914,999.50
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	25,502,283,176.23	36,793,559,547.69
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>3,670,633,080.00</b>	<b>4,433,747,157.50</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,619,303,681.00	3,530,155,052.50
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,127,999.00	55,867,500.00
210604	Урсгал засвар	1,049,201,400.00	847,724,605.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>459,845,282.00</b>	<b>128,269,487.20</b>
210701	Гадаад албан томилолт	316,386,682.00	97,328,637.20
210702	Дотоод албан томилолт	143,458,600.00	30,940,850.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>21,712,349,274.40</b>	<b>14,802,090,874.41</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	18,944,221,573.40	11,834,222,390.08
210803	Даатгалын үйлчилгээ	261,731,801.00	227,277,276.63
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	984,795,200.00	1,017,571,218.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,521,600,700.00	1,723,019,989.70
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>2,164,641,042.80</b>	<b>3,855,265,710.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	853,818,144.80	553,526,163.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,310,822,898.00	3,301,739,547.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>4,954,857,662.11</b>	<b>5,228,827,149.95</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>123,527,099.00</b>	<b>147,408,000.00</b>
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	123,527,099.00	147,408,000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>2,210,181,243.87</b>	<b>2,014,546,925.77</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	50,753,404.00	16,835,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	753,932,305.43	439,470,458.77
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,405,495,534.44	1,558,240,967.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>2,621,149,319.24</b>	<b>3,066,872,224.18</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,621,149,319.24	3,066,872,224.18
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>2,181,530,395.45</u></b>	<b><u>35,548,935,709.33</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>1,158,085,398.00</b>	<b>35,022,271,075.32</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>1,158,085,398.00</b>	<b>35,022,271,075.32</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>1,158,085,398.00</b>	<b>35,022,271,075.32</b>
220001	Барилга байгууламж	1,158,085,398.00	8,855,829,210.00
221001	Их засвар		1,670,666,075.00
222001	Тоног төхөөрөмж		24,495,775,790.32
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>-1,158,085,398.00</u></b>	<b><u>-35,022,271,075.32</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>1,023,444,997.45</b>	<b>526,664,634.01</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>857,559,955.49</b>	<b>1,881,003,952.94</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>1,881,004,952.94</b>	<b>2,407,668,586.95</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>388,984,811.40</b>	<b>33,030,298.56</b>	<b>53,591,770,723.91</b>	<b>54,013,785,833.87</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>388,984,811.40</b>	<b>33,030,298.56</b>	<b>53,591,770,723.91</b>	<b>54,013,785,833.87</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
Тайлант үеийн үр дүн		-	-13,756,663,669.03	-13,756,663,669.03
<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>330,084,811.40</b>	<b>33,030,298.56</b>	<b>39,835,107,054.88</b>	<b>40,198,222,164.84</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	739,302,385.00	739,302,385.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	330,084,811.40	33,030,298.56	40,574,409,439.88	40,937,524,549.84
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	12,851,314,251.13	12,851,314,251.13
<b>2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>330,084,811.40</b>	<b>33,030,298.56</b>	<b>53,425,723,691.01</b>	<b>53,788,838,800.97</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>59,683,080,000.00</b>	<b>58,986,179,448.00</b>	<b>696,900,552.00</b>	<b>98.8</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>59,683,080,000.00</b>	<b>58,986,179,448.00</b>	<b>696,900,552.00</b>	<b>98.8</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>58,688,703,000.00</b>	<b>56,674,557,533.96</b>	<b>2,014,145,466.04</b>	<b>96.6</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>3,836,087,300.00</b>	<b>3,390,731,745.84</b>	<b>445,355,554.16</b>	<b>88.4</b>
210101	Үндсэн цалин	2,116,543,400.00	1,869,738,335.34	246,805,064.66	88.3
210102	Нэмэгдэл	939,204,600.00	1,240,804,295.39	-301,599,695.39	132.1
210103	Унаа хоолны хөнгөлөлт	352,758,600.00	91,621,500.00	261,137,100.00	26.0
210104	Урамшуулал	427,580,700.00	188,567,615.11	239,013,084.89	44.1
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>205,912,100.00</b>	<b>74,793,901.18</b>	<b>131,118,198.82</b>	<b>36.3</b>
210201	Тэтгэврийн даатгал	13,022,500.00	6,031,266.11	6,991,233.89	46.3
210202	Тэтгэмжийн даатгал	1,450,400.00	713,287.89	737,112.11	49.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,044,000.00	356,643.94	3,687,356.06	8.8
210204	Ажилгүйдлийн даатгал	80,509,400.00	356,643.94	80,152,756.06	0.4
210205	Эрүүл мэндийн даатгал	106,885,800.00	67,336,059.30	39,549,740.70	63.0
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>252,187,900.00</b>	<b>118,614,644.64</b>	<b>133,573,255.36</b>	<b>47.0</b>
210301	Гэрэл, цахилгаан	75,402,800.00	27,052,451.84	48,350,348.16	35.9
210302	Түлш, халаалт	170,739,300.00	87,393,126.59	83,346,173.41	51.2
210303	Цэвэр, бохир ус	6,045,800.00	4,169,066.21	1,876,733.79	69.0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>425,542,100.00</b>	<b>313,761,186.00</b>	<b>111,780,914.00</b>	<b>73.7</b>
210401	Бичиг хэрэг	88,487,700.00	89,334,256.00	-846,556.00	100.9
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	121,889,800.00	121,393,910.00	495,890.00	99.6
210404	Ном, хэвлэл	27,430,000.00	26,030,000.00	1,400,000.00	94.9
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,000,000.00	1,440,000.00	560,000.00	72.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	185,734,600.00	75,563,020.00	110,171,580.00	40.7
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>37,432,161,200.00</b>	<b>36,974,671,116.19</b>	<b>457,490,083.81</b>	<b>98.8</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,674,200.00	1,775,772.00	-101,572.00	106.1
210502	Хоол, хүнс	264,449,500.00	194,563,396.50	69,886,103.50	73.6
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	37,166,037,500.00	36,778,331,947.69	387,705,552.31	99.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>4,380,806,600.00</b>	<b>4,118,212,561.50</b>	<b>262,594,038.50</b>	<b>94.0</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,245,476,500.00	3,238,994,956.50	6,481,543.50	99.8
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	65,945,900.00	55,867,500.00	10,078,400.00	84.7
210604	Урсгал засвар	1,069,384,200.00	823,350,105.00	246,034,095.00	77.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>234,368,300.00</b>	<b>128,269,487.20</b>	<b>106,098,812.80</b>	<b>54.7</b>
210701	Гадаад албан томилолт	85,688,300.00	97,328,637.20	-11,640,337.20	113.6
210702	Дотоод албан томилолт	148,680,000.00	30,940,850.00	117,739,150.00	20.8

**Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, ар талын албаны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитын тайлан**

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>8,471,155,300.00</b>	<b>8,228,692,639.41</b>	<b>242,462,660.59</b>	<b>97.1</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,316,798,600.00	5,260,824,155.08	55,974,444.92	98.9
210803	Даатгалын үйлчилгээ	234,235,800.00	227,277,276.63	6,958,523.37	97.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,178,296,900.00	1,017,571,218.00	160,725,682.00	86.3
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,741,824,000.00	1,723,019,989.70	18,804,010.30	98.9
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>3,450,482,200.00</b>	<b>3,326,810,252.00</b>	<b>123,671,948.00</b>	<b>96.4</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	224,866,800.00	224,866,705.00	95.00	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,225,615,400.00	3,101,943,547.00	123,671,853.00	96.2
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>994,377,000.00</b>	<b>2,311,621,914.04</b>	<b>-1,317,244,914.04</b>	<b>232.5</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>147,408,000.00</b>	<b>147,408,000.00</b>	<b>0.00</b>	<b>100.0</b>
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	147,408,000.00	147,408,000.00	0.00	100.0
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>846,969,000.00</b>	<b>655,594,525.77</b>	<b>191,374,474.23</b>	<b>77.4</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	16,835,800.00	16,835,500.00	300.00	100.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	440,293,900.00	439,470,458.77	823,441.23	99.8
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	389,839,300.00	199,288,567.00	190,550,733.00	51.1
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>		<b>1,508,619,388.27</b>		
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		1,508,619,388.27		
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>59,583,123,700.00</b>	<b>58,986,179,448.00</b>	<b>596,944,252.00</b>	<b>99.0</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>59,583,123,700.00</b>	<b>58,958,668,467.00</b>	<b>624,455,233.00</b>	<b>99.0</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	59,583,123,700.00	58,958,668,467.00	624,455,233.00	99.0
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	0.00	27,510,981.00	-27,510,981.00	
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		27,510,981.00	-27,510,981.00	
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>77</b>	<b>76</b>	<b>1</b>	<b>98.7</b>
620001	Удирдах ажилтан	8	8		100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	67	66	1	98.5
620003	Үйлчлэх ажилтан	2	2		100.0

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>8,906,331,735.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>8,906,331,735.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>7,606,331,735.00</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>90,000,456.00</b>
210402	Тээвэр, шатахуун	56,780,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	31,220,456.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>332,330,000.00</b>
210502	Хоол, хүнс	332,330,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>315,534,596.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	291,160,096.00
210604	Урсгал засвар	24,374,500.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>6,573,398,235.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,573,398,235.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>293,726,100.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	93,930,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	199,796,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,300,000,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,300,000,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,300,000,000.00
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>1,342,348.00</b>
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	1,342,348.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>8,906,331,735.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>8,906,331,735.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,299,898,235.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,606,433,500.00

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын үйл ажиллагаанд Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй 114 хууль, Ерөнхийлөгчийн зарлигаар баталсан 4, Монгол Улсын Их Хурлын тогтоолоор баталсан 3, Засгийн газрын тогтоолоор баталсан 72, Хууль зүй, дотоод хэргийн сайдын баталсан нийтээр дагаж мөрдөх 77, Цагдаагийн төв байгууллагын дангаар болон хамтран баталсан захиргааны хэм хэмжээ тогтоосон 14 актыг мөрдөж, хэрэгжилтийг хангуулж, хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Санхүү, ар талын албаны үндсэн үйл ажиллагааны зорилгыг “Байгууллагын үндсэн үүрэг зорилгоо ханган биелүүлэхэд төр, засгийн шийдвэрт нийцүүлэн шаардагдах төсөв зохиох, санхүүгийн эх үүсвэрийг батлуулах, зарцуулах, биелэлтэд хяналт тавих, байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангаж, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, зарцуулалтад хяналт тавих” гэж тодорхойлсон байна.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын хэвийн үйл ажиллагаа явуулах, бэлэн байдлыг хангахад шаардлагатай төсвийг төлөвлөж батлуулах, хөрөнгө, тоног төхөөрөмж, тусгай зориулалтын багаж хэрэгслийг батлагдсан төсвийн хүрээнд бэлтгэж, хуваарилах чиг үүрэг бүхий Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний ЦЕГ-ын харьяаны алба юм.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Санхүү, ар талын албыг 1934 онд анх байгуулсан бөгөөд Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/116 дугаар тушаалаар баталсан “Цагдаагийн байгууллагын зохион байгуулалтын бүтэц”-тэй нийцүүлэн ЦЕГ-ын даргын 2023 оны А/347 дугаар тушаалаар “Санхүү, аж ахуйн алба”-ны нэрийг Санхүү, ар талын алба болгон өөрчилж, зохион байгуулалтын бүтцэд өөрчлөлт оруулаагүй боловч Цагдаагийн ерөнхий газрын даргын 2025 оны А/64 дүгээр тушаалаар 2 орон тоо нэмэгдсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Албаны удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Санхүү, ар талын албаны 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус албаны санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС-д нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

#### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт Цагдаагийн ерөнхий газрын даргын 2025 оны 07 дугаар сарын 24-ны өдрийн А/287 дугаар тушаалаар “Цагдаагийн

байгууллага нь нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг байдлыг хангах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гамшиг, хорио цээрийн дэглэм сахиулах чиг үүргийн хүрээнд байгууллагын хэвийн үйл ажиллагааг тасралтгүй хангах зорилгоор стратегийн ач холбогдол бүхий бараа /шатахуун, хүнс, тусгай хэрэгсэл, галт зэвсэг, бичиг хэрэг, бусад/-ны нөөцийг тухайн жилийн баталсан төсвийн холбогдох зардлын 10 хүртлэх хувиар бүрдүүлж болно” гэсэн нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 14,154,088.8 мянган төгрөгөөр буюу 25.4 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,881,004.0	2,407,668.6	526,664.6
Авлага	52,714.0	165,994.3	113,280.3
Урьдчилгаа	17,162,602.7	8,056,535.5	-9,106,067.2
Бараа материал	4,417,886.8	17,136,603.3	12,718,716.5
Нөөцийн бараа	15,179,083.7	25,361,040.4	10,181,956.7
Үндсэн хөрөнгө	2,931,034.0	2,650,571.6	-280,462.4
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>41,624,325.0</b>	<b>55,778,413.8</b>	<b>14,154,088.8</b>
Өр төлбөр	1,426,102.8	1,989,574.9	563,472.1
Засгийн газрын хувь оролцоо	40,198,222.2	53,788,838.8	13,590,616.6
<b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>41,624,325.0</b>	<b>55,778,413.8</b>	<b>14,154,088.8</b>

Дээрх хүснэгтээс харахад дараах дансны үлдэгдэлд материаллаг дүнтэй өөрчлөлтүүд гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 2,407,668.6 мянган төгрөг болж, тайлант онд улсын төсвийн хөрөнгө оруулалт болон урсгал төсвийн санхүүжилтийн барьцааны 1,508,178.4 мянган төгрөгийг байршуулсан, 926,212.7 мянган төгрөгийн барьцааг чөлөөлснөөс шалтгаалан 526,664.6 мянган төгрөг буюу 21.9 хувиар нэмэгдсэн;
- Авлага дансны үлдэгдэл 165,994.3 мянган төгрөг болж, тайлант оны эцэст ахмадын сангийн 128,819.9 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлснээс шалтгаалан өмнөх оноос 113,280.3 мянган төгрөг буюу 68.2 хувиар өссөн. Тус дансны үлдэгдэлд малчин Б.Цэгмэдээс авах 25,631.4 мянган төгрөг, Бэхэн хур ХХК-аас авах 2,500.0 мянган төгрөг, Эм Жи Эл Вариор ХХК-аас авах 6.800.0 мянган төгрөгийн авлагууд бүртгэлтэй;
- Урьдчилгаа дансны үлдэгдэл 8,056,535.5 мянган төгрөг болж, тайлант онд Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3-т “Цэргийн алба хаагчийн нэг удаагийн тэтгэмжийн 18 сар хүртэлх хугацаанд ногдох хэсгийг цэргийн алба хаасны тэтгэвэр авах эрх үүссэнээс хойш үргэлжлүүлэн алба хааж байгаа офицер, ахлагчид өөрийн нь хүссэнээр цэргийн албанаас чөлөөлөгдөхөөс өмнө урьдчилан олгож болно” гэж заасны дагуу 13 албан хаагчдад 18 сарын урьдчилгаа 2,161,206.0 мянган төгрөгийг олгосон, Дүрэмт хувцасны материал бэлтгэхэд 1,955,594.7 мянган төгрөгийг, Санхүүгийн түрээсийн гэрээний хугацаа дууссан 68 автомашины 4,989,266.4 мянган төгрөгийн хөрөнгийг орлогод бүртгэснээс шалтгаалан өмнөх оноос 9,106,067.2 мянган төгрөг буюу 53.1 хувиар буурсан;
- Бараа материалын дансны үлдэгдэл 17,136,603.3 мянган төгрөг болж, тайлант онд Энхийг дэмжих ажиллагаанд оролцох цагдаагийн багийн тусгай хэрэгсэл бэлтгэхэд тусгай зориулалтын материал 6,522,403.5 мянган төгрөг, эм боох материал 1,775.8 мянган төгрөг, бэлэн бүтээгдэхүүн 45,407,914.9 мянган төгрөг, бичиг хэргийн материал 1,763,229.5 мянган төгрөг, аж ахуйн материал 35,464.6 мянган төгрөг, түлш шатах тослох материал 131,480.0 мянган төгрөг, барилгын засварын материал 346,627.4 мянган төгрөг, хүнсний материал 131,129.3 мянган төгрөг, бусад хангамжийн материал 36,390,060.8 мянган төгрөг, нөөцийн бараа материал 10,181,956.7 мянган төгрөг, нийт 98,214,273.5 мянган төгрөгөөр нэмэгдснээс шалтгаалан өмнөх оноос 12,718,716.5 мянган төгрөг буюу 74.2 хувиар өссөн;

- Нөөцийн бараа материал дансны үлдэгдэл 25,361,040.4 мянган төгрөг болж, тайлант онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар он дамжин санхүүжиж байгаа барилга, байгууламжийн гүйцэтгэл, барилгын зураг, зохиогч захиалагчийн хяналтыг барилгын гүйцэтгэлээс шалтгаалан үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа данснаас нөөцийн бараа дансанд бүртгэсэнтэй холбоотойгоор өмнөх оноос 10,181,956.7 мянган төгрөг буюу 40.1 хувиар өссөн;
- Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 2,650,571.6 мянган төгрөг болж, тайлант онд худалдан авсан галт зэвсгийг Цагдаа дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвд 178,407.9 мянган төгрөгийг ЦЕГ-ын даргын 2025 оны МН-1а/35 дугаартай тушаалаар балансаас баланст шилжүүлснээс шалтгаалан өмнөх оноос 280,462.4 мянган төгрөг буюу 9.6 хувиар буурсан;
- Өр төлбөрийн данс үлдэгдэл 1,989,574.9 мянган төгрөг болж, тайлант онд барьцаа, дэнчингийн өглөг 588,953.9 мянган төгрөгөөр, байгууллагад төлөх өглөг 6,988.2 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэнтэй холбоотойгоор өмнөх оноос 563,472.1 мянган төгрөг буюу 28.5 хувиар өссөн;
- Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл өмнөх оноос 13,590,616.6 мянган төгрөг буюу 25.3 хувиар өссөн нь өмнөх оны үр дүн 739,302.4 мянган төгрөгөөр, тайлант оны үр дүн 12,851,314.3 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэнтэй холбоотой байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус албаны 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвийн 208,759,287.5 мянган төгрөгийн санхүүжилтээр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлж, төсвийн саналаас цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал 13,370,628.4 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 267,408.1 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 20,750.2 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардлаас 764,053.7 мянган төгрөг, нормативт зардлаас 8,271,003.1 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардлаас 1,602,645.1 мянган төгрөг, томилолт, зочны зардлаас 408,603.6 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж зардлаас 4,417,864.3 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлаас 694,379.8 мянган төгрөг, урсгал шилжүүлэг зардлаас 1,447,766.7 мянган төгрөгийн зардлыг тус тус хасаж, нийт зардлыг 177,490,184.4 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант онд баталсан төсвийг Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалын дагуу харьяа нэгжүүдэд 84,651,731.2 мянган төгрөг хуваарилан болгож, 2025 оны төсвийн тодотголоор 33,155,072.6 мянган төгрөгөөр бууруулж, нийт 59,683,380.0 мянган төгрөгөөр баталсан байна.

#### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсөв захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 8 арга хэмжээний 59,583,123.7 мянган төгрөгийн зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэхээр баталж, гүйцэтгэлээр санхүүжилтийг бүрэн авч, 1,508,619.6 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 58,986,179.4 мянган төгрөг буюу 98.8 хувьтай байгаа нь Цалин хөлс болон нэмэгдэл урамшил 445,355.7 мянган төгрөг, Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 131,118.2 мянган төгрөг, Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 133,573.3 мянган төгрөг, Хангамж, бараа материалын зардал 111,780.9 мянган төгрөг, Нормативт зардал 457,790.1 мянган төгрөг, Эд хогшил, урсгал засварын зардал 262,594.0 мянган төгрөгийг тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Төсвийн гүйцэтгэлээр цагдаа хөтөлбөрт 50,162,166.6 мянган төгрөг буюу 95.9 хувийг, шүүгч болон гэрч, хохирогчийн хөтөлбөрт 2,150,475.9 мянган төгрөг буюу 4.3 хувийг баталсан төсвийн хүрээнд зарцуулжээ.

Нийт урсгал зардлын 36,778,331.9 мянган төгрөг буюу 70.3 хувийг нормын хувцас зөөлөн эдлэлийн, 8,228,692.6 мянган төгрөг буюу 15.7 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн, 3,390,731.6 мянган төгрөг буюу 6.5 хувийг цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын, 7.5 хувийг бусад зардал тус тус эзэлж байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/					
Код	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	<b>Нийт дүн</b>	<b>54,525,865,600.00</b>	<b>52,312,642,488.73</b>	<b>2,213,223,111.27</b>	
<b>70704</b>	<b>Цагдаа</b>	<b>52,138,069,900.00</b>	<b>50,162,166,614.93</b>	<b>1,975,903,285.07</b>	
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	50,984,408,700.00	49,235,746,353.16	1,748,662,346.84	96.6
80220	Холбооны суваг ашигласны хөлс	50,074,200.00	50,074,200.00	-	100
80509	ОУ-ын байгууллагын гишүүнчлэлийн хураамж	147,408,000.00	147,408,000.00	-	100
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж	846,969,000.00	655,594,525.8	191,374,474.23	77.4
82315	Байцаан шийтгэх ажиллагаа	86,543,900.00	50,678,426	35,865,474.00	58.6
82324	Мөнгө угаах, терроризмийг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаа	22,666,100.00	22,665,110.00	990.00	99.9
<b>70711</b>	<b>Шүүгч болон гэрч, хохирогч</b>	<b>2,387,795,700.00</b>	<b>2,150,475,873.80</b>	<b>237,319,826.20</b>	
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	2,387,795,700.00	2,150,475,873.80	237,319,826.20	90.6

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Санхүүгийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу судалгааг авч, дүн шинжилгээ хийж үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

1. ЦЕГ-ын даргын 2023 оны А/347 дугаар тушаалаар “Санхүү, аж ахуйн алба”-ны нэрийг Санхүү, ар талын алба болгон өөрчилж, зохион байгуулалтын бүтцэд өөрчлөлт оруулаагүй, тайлант онд 1 орон тоогоор хэмнэн ажиллаж, цомхотгол хийгээгүй байна. Цалингийн зардалд 3,836,087.3 мянган төгрөг баталснаас, гүйцэтгэлээр 3,390,731.6 мянган төгрөгийг зарцуулсан;
2. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2025 оны А/212 тушаалаар өдрийн 8 цагаар ажилладаг албан хаагч нарт 10.0 мянган төгрөг, гараагаар буюу ээлжээр ажилладаг алба хаагч нарт 20.0 мянган төгрөгийн унаа, хоолны хөнгөлөлт олгохоор тогтоосон;
3. Гадаад томилолтын зардалд 85,688.3 мянган төгрөг баталснаас, гүйцэтгэлээр 85,688.3 мянган төгрөгийг Үндэстэн дамнасан гэмт хэргийн эсрэг Олон улсны интерполын чуулга уулзалт, сургалт ялтан шилжүүлэн авч ирэх зарда, бараа үйлчилгээний бусад зардлаас 47,773.9 мянган төгрөгийг Интерполын "Хөх булант" зар мэдээгээр Олон Улсад эрэн сурвалжлагдаж байгаа МУ-ын иргэдийг шилжүүлэн авч ирэх үеийн зардалд зарцуулж, харин дотоод томилолтын зардлаас 11,640.3 мянган төгрөгийг гадаад томилолтын зардалд зарцуулсаныг алдаа зөрчлөөр тусгасан.;
4. Энхийг дэмжих ажиллагаанд оролцох цагдаагийн багийн бэлтгэл сургалт, семинар, хурал, зөвлөгөөний зардалд 3,208,876.9 мянган төгрөг, Олон Улсын болон Төрийн цэргийн байгууллагын алба хаагчдын хурал зөвлөгөөнд 92,862.6 мянган төгрөгийг тус тус зарцуулсан;

5. Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай байгуулсан ажил, үйлчилгээний гэрээ байгуулаагүй, ямар нэгэн зардал гараагүй;
6. Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал гараагүй;

Баталсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.5.3 Нэмэлт төсөв**

Тус албаны удирдлага Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар Засгийн газрын нөөц хөрөнгөөс 6,299,898.2 мянган төгрөгийн санхүүжилт, дээд шатны төсвийн захирагчаас 2,606,433.5 мянган төгрөгийн доод шатны төсвийн захирагчид хуваарилсан санхүүжилт, нийт 8,906,331.7 мянган төгрөгийг орлогыг бүрдүүлж, зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.6 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл**

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн А/08 дугаар тушаалаар баталсан “Цагдаагийн ерөнхий газрын 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө”-нд 72,350,473.9 мянган төгрөгийн 37 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна.

Тайлант онд дээрх төлөвлөгөөг сайдын 2025 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн А/105 дугаар тушаалаар тодотгол хийж 19 төсөл, арга хэмжээнд 12,000,679.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, нийт 56 төсөл, арга хэмжээнд 84,351,153.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Нийт 95 төсөл, арга хэмжээний бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулж, нийт 196 хуулийн этгээдтэй 157,108,097.9 мянган төгрөгийн гэрээ байгуулж, тайлант хугацаанд 158 гэрээний хэрэгжилтийг хянаж, дүгнэсэн, 7 гэрээ он дамжин хэрэгжиж байна.

Тайлант хугацаанд тендерийн урилгыг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем /www.tender.gov.mn/-д холбогдох хууль, журмын дагуу байршуулсан боловч зарим бараа, ажил, үйлчилгээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан тендер шалгаруулалтын гэрээ дүгнэсэн актыг байршуулаагүй, мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллаагүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, ар талын албаны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн Санхүү, ар талын алба, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн санхүүгийн үйл ажиллагаа нягтлан бодох бүртгэлийг сайжруулах зорилгоор үр ашиггүй зардал гаргахгүй байх талаар өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Санхүү, нийцлийн аудитын газрын ахлах аудитор С.Отгонхорлоо, аудитор С.Шийлэгмаа нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Б.Долгорсүрэн, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Санхүү, ар талын албаны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 19/258 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 79,548,664.3 мянган төгрөгийн 1 хувиар буюу 795,486.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.3.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээг бүрэн мэдээлсэн байна.

#### 4.3.2 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор төсвийн шууд захирагч төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах дараах арга хэмжээг авч ажилласан байна. Тухайлбал:

- Тайлант онд цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын хэмжээнд ашиглаж байгаа суурин утас, жижүүрийн шуурхай удирдлагын иргэдээс гомдол мэдээлэл авдаг үүрэн телефоны утасны хураамжаас бусад зардлыг гаргаагүй;
- Байрны түрээс, ном хэвлэл, хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал, эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл, зочин төлөөлөгч хүлээн авах зардлын төсвийг батлуулаагүй;

- Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд мэдээллэх зорилгоор улирал бүр “Цагдаа” сэтгүүлийг ЦЕГ-ын Хэвлэл мэдээллийн төв бэлтгэн олон нийтэд хүргэж байна.

#### 4.4 Завсрын аудитын үр дүн

Завсрын аудитаар аудитын төлөвлөх үе шатны ажилбарыг хэрэгжүүлж, аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийг батлуулсан.

#### 4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар нийт 1,630,996.0 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг илрүүлснээс 1,587,483.3 мянган төгрөгийн 6 алдааг залруулж, 43,407.4 мянган төгрөгийн зөрчлийг арилгуулахаар албан шаардлага, 8,676.7 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгсөн байна.

Цагдаа, дотоодын цэргийн анги байгууллагын 2024 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд хийсэн аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг хуульд заасан хугацаанд нэгдсэн байдлаар, Санхүү, ар талын албанд өгсөн аудитын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг тусад нь боловсруулж ирүүлсэн байна.

Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, ар талын албаны 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 16/4155 дугаар албан бичгээр аудитын шийдвэрийн хэрэгжилтийн тайлан, нотлох баримтыг ирүүлсэн байна.

Аудитын шийдвэрийн хэрэгжилтийг ирүүлсэн нотлох баримтад тулгуурлан үнэлэхэд 100.0 хувь хэрэгжсэн байна.

*Хүснэгт 3. Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	3	34,730.7	3	34,730.7	100.0
Зөвлөмж	3	8,676.7	3	8,676.7	100.0
<b>Нийт дүн</b>	<b>6</b>	<b>43,407.4</b>	<b>6</b>	<b>43,407.4</b>	<b>100.0</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитын явцад дараах асуудлыг нэмж тодруулах шаардлагатай байна. Үүнд:

1. Санхүү ар талын албаны санхүүгийн тайланд 2022 онд 808,185.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан шатахуун, тослох материал нь жил дараалан өссөн үзүүлэлттэй байгаа бөгөөд тайлант оны эцэст 1,006,416.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Аудитын явцад биет тооллого хийхэд 103,875.0 мянган төгрөгийн толаны үлдэгдэл бэлэн тоологдсон. Харин Петро смар ХХК-ийн картан дансанд 902,551.5 мянган төгрөг байршиж байгаа гэх боловч байгууллагын нэр дээрх картанд тус мөнгийг байршуулсан эсэх, Петро смарт ХХК-тай гэрээ байгуулсан эсэх нь нотлогдохгүй, хэрэглээний бодит байдлыг бүрэн тайлбарлаж, нотлож чадаагүйг асуудал;
2. Нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зохицуулах салбар зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу "Иргэд олон нийтийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учрахаас хамгаалсан, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд идэвх санаачилга гарган ажилласан алба хаагчдад шаардагдах зардал"-д батлагдсан хөрөнгийг 2025.11.28-ны А/273 тоот "Эрх шилжүүлэх тухай" захирамжаар 1,300,000.0 мянган төгрөгийг 83 албан хаагчдад 10,000.0-20,000.0 мянган төгрөгийн нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд зарцуулсан;
3. Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлаас санхүүгийн түрээсээр 3,000,000.0 мянган төгрөгийн автомашин худалдан авч, 501.1 мянган төгрөгийн өр үүсгэж, баталсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан зэрэг асуудлуудыг дараагийн аудитаар авч үзэхээр шийдвэрлэв.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2,943,267.7 мянган төгрөгийн алдааг<sup>1</sup> илрүүлж, аудитын явцад залруулсан.

*Залруулсан алдаа:*

- Санхүүгийн тайлангийн нөөцийн дансанд бүртгэлтэй, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан 885,488.5 мянган төгрөгийн Хэнтий аймгийн Баян-Овоо сумын Цагдаагийн газрын барилга, Оч зуслангийн 1,238,112.2 мянган төгрөг, Хангалтын агуулахын 109,600.0 мянган төгрөг, Нарстай сургалтын талбай 710,106.0 мянган төгрөгийн их засварын ажлууд дуусаж, улсын комисс хүлээн авсан боловч Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас тэдгээр хөрөнгийг эзэмших, бүртгэх зөвшөөрөл гараагүй байхад харьяа байгууллагын дансанд бүртгүүлэхээр данснаас хассан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл 5.1-т "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална", 5.1.4-т "үнэн зөв байх", санхүүгийн тайлагналын "Толилуулга", "Ангилал болон ойлгомжтой байдал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 239,714.3 мянган төгрөгийн зөрчлийг<sup>2</sup> илрүүлж, 73,008.8 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 38,077.5 мянган төгрөгийн зөрчлийг таслан зогсоох 1 албан шаардлага, 128,628.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 2 зөвлөмж өглөө.

### 5.1 Төлбөрийн акт

#### 1. Барьцаа, дэнчингийн өглөгтэй холбоотой

**Илрүүлэлт 1.** Тайлант онд барьцаа хөрөнгийн дансанд 2018-2022 онд байршуулсан гүйцэтгэлийн болон зүгшрүүлэх, тохируулах хугацааны чанарын баталгааны 5 хувийн барьцааг чөлөөлөх талаар 19 аж ахуйн нэгж, байгууллагад албан бичиг хүргүүлсэн боловч 11 аж ахуйн нэгж, байгууллага 73,008.8 мянган төгрөгийн чанарын баталгааг цуцлуулах албан хүсэлт ирүүлээгүй, чанарын баталгаа байршуулсан хуулийн хугацаа дууссан, тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "хариуцлагатай байх", 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-т "Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Барьцаа хөрөнгийн дансанд 2018-2022 онд байршуулсан гүйцэтгэлийн болон зүгшрүүлэх, тохируулах хугацааны чанарын баталгааны 5 хувийн барьцааны хуулийн хугацаа дууссан 73,008.8 мянган төгрөгийн Төрийн сан дахь Үндэсний аудитын газрын Аудитын шалгалтын орлогын 100900000601 дугаар дансанд төвлөрүүлэх.

### 5.2 Албан шаардлага

#### 1. Авлага, өглөгийн данстай холбоотой

**Илрүүлэлт 1.** Найдваргүй авлага болох эрсдэлтэй, олон жилийн насжилттай тусгай зориулалтын 1,683.1 мянган төгрөг, малчнаас авах 25,631.4 мянган төгрөг, Бэхэн хур ХХК-аас авах 2,500.0 мянган төгрөг, Эму Жи Эл Вариор ХХК-аас авах 6,800.0 мянган төгрөг,

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Саунд мюзик студи ХХК-аас авах 560.0 мянган төгрөгийн авлага, хувь хүнд өгөх 240.0 мянган төгрөг, байгууллагад төлөх 663.0 мянган төгрөгийн өглөг, нийт 38,077.5 мянган төгрөгийн авлага, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Найдваргүй авлага болох эрсдэлтэй, олон жилийн насжилттай авлага, өглөгийн үлдэгдлийн тооцоог нийлж, актаар баталгаажуулан, барагдуулах арга хэмжээ авч, зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэв..

### **5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал**

**Илрүүлэлт 1.** Гадаад томилолтын баталсан төсвийг 11,640.3 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 5 дугаар зүйлийн 5.1.5-д “хариуцлагатай байх” гэж заасныг зөрчсөн байна.

**Өгсөн зөвлөмж:** Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, санхүүгийн тайланд холбогдох, хууль, журамд заасан дансны ангиллын дагуу үнэн зөв тайлганах.

#### **2. Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал**

**Илрүүлэлт 2.** Баталсан төсвөөс 116,987.7 мянган төгрөгийн бэлэг дурсгал, цом, цэцгийн баглаа, дэвтэр, бал, мандат зэргийг худалдан авч, төсвийг үр ашиггүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 5 дугаар зүйлийн 5.1.5-д “хариуцлагатай байх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5.төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах" гэснийг тус тус зөрчсөн байна.

**Өгсөн зөвлөмж:** Баталсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, санхүүгийн тайланд холбогдох, хууль, журамд заасан дансны ангиллын дагуу үнэн зөв тайлганах.

Дээрх зөвлөмжийг биелүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуульд заасан хугацаанд гаргаж УАГ-т ирүүлэх, биелэлтийн тайлан, нотлох баримтыг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ****Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

д/д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Санхүүгийн тайлангийн нөөцийн дансанд бүртгэлтэй, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан 885,488.5 мянган төгрөгийн Хэнтий аймгийн Баян-Овоо сумын Цагдаагийн газрын барилга, Оч зуслангийн 1,238,112.2 мянган төгрөг, Хангалтын агуулахын 109,600.0 мянган төгрөг, Нарстай сургалтын талбай 710,106.0 мянган төгрөгийн их засвар ажлууд дуусаж, улсын комисс хүлээн авсан боловч Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас тэдгээр хөрөнгийг эзэмших, бүртгэх зөвшөөрөл гараагүй байхад харьяа байгууллагын дансанд бүртгүүлэхээр данснаас хассан байна.	1	2,943,267.6			1	2,943,267.6	1	2,943,267.6				
<b>Дүн</b>		<b>1</b>	<b>2,943,267.6</b>	-	-	<b>1</b>	<b>2,943,267.6</b>	<b>1</b>	<b>2,943,267.6</b>	-	-	-	-

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	тоо	Дүн	Тоо	Дүн
1	Санхүү ар талын албаны Хангамжийн хэлтэс нь барьцаа хөрөнгийн дансанд байршиж байгаа 2018-2022 оны чанарын баталгааны 5 хувийн барьцааг чөлөөлөх 19 аж ахуй нэгжид албан тоот хүргүүлэн ажилласан боловч 11 аж ахуй нэгж байгууллага чанарын баталгаа цуцлуулах албан хүсэлт ирүүлээгүй, 73,008,770.95 мянган төгрөгийн өглөгт тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй, хуулийн хугацаа дууссан байна.	1	73,008.80	1	73,008.80								
2	Найдваргүй авлага болох эрсдэлтэй, олон жилийн насжилттай 1,683.1 мянган төгрөгийн тусгай зориулалтын авлага, малчнаас авах 25,631.4 мянган	1	38,077.50			1	38,077.5						

	төгрөг, Бэхэн хур ХХК-аас авах 2,500.0 мянган төгрөг, Эму Жи Эл Вариор ХХК-аас авах 6.800.0 мянган төгрөг, Саунд мюзик студи ХХК-аас авах 560.0 мянган төгрөгийн авлага, 240.0 мянган төгрөгийн хувь хүнд өгөх өглөг, 663.0 мянган төгрөгийн байгууллагад төлөх өглөг, нийт 38,077.5 мянган төгрөгийн авлага, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй байна.												
3	Гадаад томилолтын зардлыг батлагдсан төсвөөс 11,640.3 мянган төгрөгийг илүү зарцуулсан.	1	11,640.30					1	11,640.3				
4	Батлагдсан төсвөөс бэлэг дурсгалын цом, цэцгийн баглаа, дэвтэр, бал, мандат зэрэгт 116,987.7 мянган төгрөгийг худалдан авч, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан байна.	1	116,987.70					1	116,987.70				
<b>Дүн</b>		<b>4</b>	<b>239,714.3</b>	<b>1</b>	<b>73,008.8</b>	<b>1</b>	<b>38,077.5</b>	<b>2</b>	<b>128,628.0</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 62/А 1560348

Улаанбаатар хот

САГ - 2026/297/НА - СТА - ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, ар талын албаны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийхэд аудитаар дараах зөрчил илэрлээ.

Тайлант онд барьцаа хөрөнгийн дансанд 2018-2022 онд байршуулсан гүйцэтгэлийн болон зүгшрүүлэх, тохируулах хугацааны чанарын баталгааны 5 хувийн барьцааг чөлөөлөх талаар 19 аж ахуйн нэгж, байгууллагад албан бичиг хүргүүлсэн боловч 11 аж ахуйн нэгж, байгууллага 73,008,770.95 /Далан гурван сая найман мянга долоон зуун далан төгрөг ерэн таван мөнгө/-ний чанарын баталгааг цуцлуулах албан хүсэлт ирүүлээгүй, чанарын баталгаа байршуулсан хуулийн хугацаа дууссан, тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “хариуцлагатай байх”, 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-т “Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.8-т “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэж заасныг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Барьцаа хөрөнгийн дансанд 2018-2022 онд байршуулсан гүйцэтгэлийн болон зүгшрүүлэх, тохируулах хугацааны чанарын баталгааны 5 хувийн барьцааны хуулийн хугацаа дууссан 73,008,770.95 /Далан гурван сая найман мянга долоон зуун далан төгрөг ерэн таван мөнгө/-ийг Төрийн сан дахь Үндэсний аудитын газрын Аудитын шалгалтын орлогын 100900000601 дугаар дансанд төвлөрүүлэх;

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-261230

Z:\Akt\2026\0225 SAG-33.Docx

1526160486

2. Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, ар талын албаны дарга, цагдаагийн хурандаа (Д.Батчулуун), Цагдаагийн ерөнхий газрын ерөнхий нягтлан бодогч бөгөөд Санхүүгийн хэлтсийн дарга, цагдаагийн хошууч (М.Ралдийжамц) нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР  
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ  
Б.ДОЛГОРСҮРЭН  
С.ОТГОНХОРЛОО  
С.ШИЙЛЭГМАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 317/А1560348

Улаанбаатар хот

САГ-2026/297/НА-СТА-ТМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, ар талын албаны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийхэд дараах зөрчил илэрлээ.

Найдваргүй авлага болох эрсдэлтэй, олон жилийн насжилттай тусгай зориулалтын 1,683,116.00 /Нэг сая зургаан зуун наян гурван мянга нэг зуун арван зургаан/ төгрөг, малчнаас авах 25,631,400.00 /Хорин таван сая зургаан зуун гучин нэгэн мянга дөрвөн зуун/ төгрөг, Бэхэн хур ХХК-аас авах 2,500,000.00 /Хоёр сая таван зуун мянган/ төгрөг, Эму Жи Эл Вариор ХХК-аас авах 6,800,000.00 /Зургаан сая найман зуун мянган/ төгрөг, Саунд мюзик студи ХХК-аас авах 560,000.00 /Таван зуун жаран мянган/ төгрөгийн авлага, хувь хүнд өгөх 240,000.00 /Хоёр зуун дөчин мянган/ төгрөг, байгууллагад төлөх 663,000.00 /Зургаан зуун жаран гурван мянган/ төгрөгийн өглөг, нийт 38,077,516.00 /Гучин найман сая далан долоон мянга таван зуун арван зургаан/ төгрөгийн авлага, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй байна.


Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.7-д “авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй” гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

- Найдваргүй авлага болох эрсдэлтэй, олон жилийн насжилттай авлага, өглөгийн үлдэгдлийн тооцоог нийлж, актаар баталгаажуулаагүй, барагдуулах арга хэмжээ аваагүй, зөрчлийг арилгаж, биелэлтийн тайлан, нотлох баримтыг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
- Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, ар талын албаны дарга, цагдаагийн хурандаа (Д.Батчулуун), Цагдаагийн ерөнхий газрын ерөнхий нягтлан бодогч бөгөөд Санхүүгийн хэлтсийн дарга, цагдаагийн хошууч (М.Ралдийжамц) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР  
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ  
Б.ДОЛГОРСҮРЭН  
С.ОТГОНХОРЛОО  
С.ШИЙЛЭГМАА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-43.Docx

1526180660